



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/17

Арвайхээр сум

**Аймгийн залуучуудын хөгжлийн салбар
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйл, 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Дүрэм батлах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах, салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл нь Засгийн газрын 2018 оны “Дүрэм батлах тухай” 04 дүгээр тогтоолоор батлагдсан дүрмийн дагуу аймаг орон нутгийн түвшинд удирдлага арга зүйгээр ханган, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Залуучуудын хөгжлийг дэмжих төвийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн нарийн бичиг (Ц.Содномдорж)-д даалгасугай.

3.Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/41 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

5224 11 0035

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдрийн 17 дугаар
захирамжийн хавсралт



ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар зөвлөлийн дарга: Аймгийн Засаг дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Статистикийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Засаг даргын Тамгын газрын Залуучуудын хөгжлийн төвийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн